

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2 Төслийн байршил	2
1.3 УУЛЫН ХЭСЭГ	4
1.4 Бохирдол.....	5
1.5 Уурхайн хүчин чадал, ажиллах горим.....	5
1.6 Ордыг ашиглах уул- геологи, уул-техникийн нөхцөл	5
1.7 Өрөмдлөгийн тоног төхөөрөмжийн сонголт	6
1.8 Баяжуулах технологийн сонголт.....	6
1.9 Тоног төхөөрөмжийн сонголт.	7
1.10 Баяжуулах цехийн ажиллах горим, хүчин чадал	7
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
1.11 Боломжит нөлөөллийн тодорхойлолт.....	10
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
1.12 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	14
1.13 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
1.14 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
1.15 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 17	
1.16 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	18
1.17 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
1.18 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
1.19 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
1.20 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	20
1.21 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
1.22 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.	24
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	
25	

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Булган Уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийн
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээ: Регистрийн дугаар :	“Ди Жи Ти энд Эм” ХХКомпани 9011483108 5853583
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6 бичил хороолол, Хасбаатар 24, 106. Утас: 99082707.
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-013378/24.74/

1.2 Төслийн байршил

“Булган Уул”-ын талбай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт байрлах бөгөөд 380км зайд 25 га талбайг хамран оршино. Хэнтий аймгийн төв Хэрлэн сумаас зүүн хойш 52 км зайд дараах газар зүйн солбицолд байрлана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл


№	Уртраг			Өргөрөг		
1	110	58	41	47	37	34
2	110	58	41	47	37	50
3	110	59	05	47	37	50
4	110	59	05	47	37	34

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршил

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ДИ ЖИ ТИ ЭНД ЭМ ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШЛЫН ТОЙМ ЗУРАГ



Нөөц тооцсон үндсэн зарчим ба үндэслэл:

Булган-Уулын хайлуур жоншны ордод хүдрийн 3 үндсэн хүдрийн биетэд нөөцийг бодит-В, болон боломжит-С зэргээр нөөцийг тооцжээ. Энэхүү хүдрийн 3 биетүүд нь өмнө нь гадаргуу дээр 60-80м-н зайтай суваг малталтууд, 62-253м-ийн гүнд 45-110м-ийн торлолтой 40 цооногоор үнэлэгдсэн бөгөөд хайгуулын шугам хоорондын зайг нягтруулан шурф нэвтрэлт 18-25м нэвтрэн судлагдсан ба 140м-240м урттай 0.6-11.6 м өргөнтэй 72°-89°-ын уналтай, шугаман байрлалтай судлын биетүүд тул геологийн блокийн аргаар, босоо тусгалын хавтгайд проекцлон, AutoCad-2008 программ ашиглан тархалтын талбай, эзлэхүүнийг тооцон, эзлэхүүн жинг Бэрхийн бүлэг ордын дунджаар 2.7т/м³-ээр авч блок тус бүрээр хүдрийн жинд шилжүүлж CaF₂-ын дундаж агуулгаар ашигт эрдсийн хэмжээг тодорхойлжээ. Хүдрийн биетүүдийн жинхэнэ зузааныг тооцохдоо малталт бүрийн доторх үзэгдэх зузааныг хүдрийн биетийн уналын өнцөгтэй харьцуулж гаргасан байна. Нөөцийн хэсэглэл дахь хүдрийн биетийн дундаж зузааныг болон сорьцын дундаж агуулгыг тооцохдоо бүх малталт, шурф, цооногууд дахь хүдрийн жинхэнэ зузааныг арифметикийн дунджаар, ашигт эрдсийн дундаж агуулгыг тооцохдоо малталт, шурф, цооногууд дахь сорьцыг арифметикийн дунджаар тооцжээ.

Хүснэгт 2. 13378А Тусгай зөвшөөрөл бүхий талбайн “Булган-Уул” ордын 1-р хүдрийн биетэд бодогдсон нөөцийн тооцооны нэгтгэл

Блок ийн зэрэг	Хайгуулын ажлын талбай	Бодит зузаан	Блокийн	Хүдрийн эзэлхүүн	Нөөц /тн/
----------------	------------------------	--------------	---------	------------------	-----------

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

			Талбай (м ²)	Эзэлхүүн (м ³)		Хүдэр	CaF ₂ -ны агуулга (%)	CaF ₂
Хүдрийн биет-1								
	ХБ1-С-1	5,9					28,89	
	ХБ1-С-2	1,4					62,35	
	Б1-С-3	5,8					49,27	
	ХБ1-С-4	0,5					80,70	
	ХБ1-С-5	1,4					75,83	
	Б1-С-6	2,0					56,1	
1-В-1	ХБ1-С-7	1,9					22,96	
	ХБ1-Ш-1	5,5					63,17	
	ХБ1-Ш-2	1,3					63,94	
	ХБ1-Ш-3	4,5					58,11	
	ХБ1-Ш-4	0,5					85,74	
	ХБ1-Ш-5	1,3					70,9	
	ХБ1-Ц-526	1,27					30,85	
	ХБ1-Ц-528	2,93					37,23	
	Нийт	36,2					786,04	
	Дундаж	2,58	7619	19657,0	2,7	53073,9	51,14	27141,9
	ХБ1-С-7	1,9					22,96	
	ХБ1-Ц-526	1,27					30,85	
	ХБ1-Ш-5	1,3					70,9	
	ХБ1-Ш-4	0,5					85,74	
	ХБ1-Ц-71	1,5					14,58	
	ХБ1-Ш-3	4,5					58,11	
	ХБ1-Ш-2	1,3					63,94	
	ХБ1-Ц-522	1,5					30,15	
1-С-1	ХБ1-Ш-1	5,5					63,13	
	ХБ1-Ц-73	2,52					24,87	
	ХБ1-Ц-528	2,93					37,23	
	ХБ1-С-1	5,9					28,89	
	Нийт	30,62					531,39	
	Дундаж	2,55	23354	59552,7	2,7	160792,29	44,28	71198,8
1-р хүдрийн биетийн хэмжээнд В-зэргээр						53073,9	51,14	27141,9
1-р хүдрийн биетийн хэмжээнд С-зэргээр						160792,29	44,28	71198,8
1-р хүдрийн биетийн хэмжээнд В+С зэргээр						213866,19		98340,7

1.3 УУЛЫН ХЭСЭГ

*Хүснэгт 3.. Далд уурхайн талбайн хил хязгаар доторх ашигт малтмалын
геологийн болон үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо*

Блок	Геологийн нөөц			Хаягдал			Хаягдал тооцсон нөөц			Бохирдол чулуу (тн)	Олборлох нөөц		
	Хүдэр (тн)	CaF ₂ агуулга (%)	CaF ₂ (тн)	(%)	Хүдэр (тн)	CaF ₂ (тн)	Хүдэр (тн)	CaF ₂ (тн)	(%)		Хүдэр (тн)	CaF ₂ агуулга (%)	CaF ₂ (тн)
В-1	53073	51,14	27141	10,59	5620	2874	47453	24267	4	1898	49351	49,17	24267
С-1	21435	44,28	9491	14,18	3039	1346	18396	8145	4	736	19132	42,57	81,45
Нийт	74508	49,17	36632	11,62	8659	4220	65849	32412	4	2634	68483	47,33	32415

1.4 Бохирдол

Хүдрийн бохирдол өрөмдлөг тэсэлгээний ажлаар зөвхөн хүдэр, хажуугийн чулуулгийн хил заагт үүсэх магадлалтай. Энэ нь 0,1 м чулуу дагаж унахаас илүү бохирдол үүсэхгүй гэж тооцож байна. Иймд бохирдлын хувь нь $X\% = \frac{0.1}{2.58} \cdot 100 = 3.87\%$ байна.

1.5 Уурхайн хүчин чадал, ажиллах горим

2024 онд жилд 8483 тн хүдэр олборлон, гар аргаар бүхэллэг жонш ялгаж, экспортод гаргахаар тооцсон болно.

Хоногийн хүчин чадал -8483:220=38.55т байна.

Ээлжид 19.25 тн, цагт 2.44 тн хүдэр гаргана.

Уурхайн хүчин чадлыг ажиллах хугацааг харгалзан тооцож, жилд ажиллах хоногийг дараах байдлаар тооцож гаргав. Уурхай нь бүтэн жилийн турш хөдөлмөрийн хуулийн дагуу 20 хоног ажиллаж 10 хоног амрахаар ээлж солих ба хоногт 2 ээлжтэй бөгөөд нийт 3 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа газрын доорх ажилчдад 11 цаг, газрын дээрх ажилчдад 12 цагаар тогтоосон горимоор ажиллана.

Хүснэгт 4. Далд уурхайн ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Далд уурхайд	Газрын дээр
1	Календарь хоног	хоног	365	365
2	Баяр ёслол	хоног	12	12
3	Ээлжийн ажилчдын амралт	хоног	107	105
4	Засвар үйлчилгээ	хоног	26	30
5	Цаг агаараас хамаарсан сул зогсолт	хоног	7	7
6	Уурхайн цэвэр ажлын хоног	хоног	320	316
7	Хоногийн ээлжийн тоо	ээлж	2	2
8	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	11	12
9	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.75	0.8
10	Уурхайн хоногт ажиллах бодит цаг	цаг	16.5	19.2
11	Уурхайн жилд ажиллах бодит цаг	цаг	5300	6000

1.6 Ордыг ашиглах уул- геологи, уул-техникийн нөхцөл

- хүдрийн биетийн дундаж зузаан 2.58 м
- эзлэхүүн жин 2.7т/м³,
- уналын өнцөг 72°-82°,
- хүдэр болон чулуулгийн тогтворшил дунд зэрэгт хамаарагдаж байна.
- чулуулгийн бат бэхийн коэффициент, f=8-10,
- хүдрийн нягт, 2.7т/м³

Чулуулгийн бүтцийн олон төрөл, түүнд хөгжсөн ан цав, хагарал нь уст үе хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Ихэвчлэн чулуулгийн үе нь хагарал бутралд хүчтэй автсан бүсүүдтэй салаавчлан байрладаг.

1.7 Өрөмдлөгийн тоног төхөөрөмжийн сонголт

Орд газар нь босоо уналтай, хүдрийн биет нь нимгэн зузаантай 2,55-2,58 м, ашиглалтын чиглэл уналын дагуу чиглэсэн, хатуулаг нь проф. М.Н.Протодъяконовын ангиллаар $f = 8-10$ тул шпурэн цэнэгийн аргаар хүдэр нураах бөгөөд хэвтээ, налуу чиглэлд өрөмдөх зориулалт бүхий зөөврийн ПП–63В маркийн өрмийн машин сонгон авлаа. Дээрх өрмийн машины техникийн үзүүлэлтийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Өрмийн машины бүтээл болон хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Перфоратор ПП–63В Зөөврийн
1	Цохилтын энерги	Дж	63
2	Цохилтын давтамж	мин-1	1800
3	Эргэлтийн момент	Н*м	27
4	Хийн зарцуулалт	м3/мин	3.5
5	Жин	кг	30

1.8 Баяжуулах технологийн сонголт

Булган-Уулын хайлуур жоншны уурхайн хүдэр баяжуулах технологийн схемийг MINLAB лабораторийн санал болгож буй хүдрийг гараар ялгах технологийн схемийг боловсруулав. Энэ арга нь эрдсийн өнгө, гялтганах шинж чанар, цацраг идэвхт чанар, гэрлийн ойлт зэрэг шинж чанарын ялгаан дээр үндэслэдэг. Гараар ялгахад хүдрийн ширхэглэлийн хэмжээ 25-250мм байх шаардлагатай.

Булган-Уул хайлуур жоншны ордын дээжүүдэд технологийн туршилтыг Уул уурхайн судалгаа шинжилгээний “Минлаб” ХХК-д хийлгэсэн. Булган-Уул хайлуур жоншны ордын технологийн бодисын найрлагын судалгааг хийж, тус технологийн дээжинд минералог-минерограф-петрографийн шинж чанарын онцлогт дүн шинжилгээ өгсөн. Гравитац-флотаци, шууд флотаци, гидроциклон-флотацийн аргуудыг хэрэглэсэн туршилтын үр дүнгүүдийг гарган тавьж тухайн ордын баяжуулалтын технологийг тогтоосон. Дээжийн баяжигдах чанарын технологийн судалгааг явуулах үед бүхэллэг, гравитацын болон флотацийн баяжмал гарган авах баяжуулалтын технологийг хэрэглэх боломжтой эсэх, баяжмалуудын технологийн үзүүлэлтүүдийг харьцуулахад анхаарлаа хандуулсан байна.

-Шинжилгээний үр дүн: Булган-Уулын орд нь кварц флюоритын төрлийн ордод хамаарна. Баяжигдах чанарын технологийн судалгааг 58,2%-ийн агуулга бүхий хүдрийн дээжин дээр явуулсан. Туршилтын үр дүнд ФК-75, ФК-85, ФК-92, ФФ-95 маркийн хайлуур жоншны баяжмал гарган авах боломжтой нь тогтоогдсон. Үүнд:

-Ангилан ялгах аргаар гарган авах үед бүхэллэг жоншны баяжмалын гарц ФК-75- 46,3%, ФК-85- 12,2%, ФК-92-7,4% тус тус байв. Хүдэр нь гравитацын аргаар баяжигдах нь дунд зэрэг байх ба өндөр маркийн гравитацийн баяжмал гарган авах бололцоо муу байгаа тул энэ шатыг алгасан гар ялгалт-флотаци гэсэн схемээр ажиллах боломжтой байна. Булган-Уулын хайлуур жоншны ордын хүдэр нь хялбар баяжигдах хүдрийн ангилалд хамаарна.

1.9 Тоног төхөөрөмжийн сонголт.

Баяжуулах цехийн ажлын горим, технологийн үндсэн тооцоог үндэслэн дараах тоног төхөөрөмжийг сонгов. Хятад улсын Zenith Electric Power Equipment Co.Ltd үйлдвэрийн баяжуулалтын тоног төхөөрөмжүүд нь овор багатай, харьцангуй хямд үнэтэй, хөдөлмөрийн бүтээмж өндөр, ашиглалтын зардал багатай зэрэг давуу талуудтай болно.

Хүснэгт 6. Техник, тоног төхөөрөмжүүдийн техникийн тодорхойлолт

№	Техник, тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үнэ мян. төг	Хүчин чадал	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	Тоо ширхэг
1.	Бутлуур	PE400x600	4500	25 т/цаг	15 квт	1 ком
2.	Туузан дамжуулагч	FC 600	15600	10 т/цаг	2,2	7
3.	Шигшүүр	XB-2000	6500	80 т/цаг	7,5 квт	1
4.	Нийт		26600		24,7	

Далд уурхайгаас тэсэлгээгээр -200мм хүртэл бутлагдсан хүдрийг тээвэрлэн ирж, бутлуурын дээр байрлах 100X100 сараалжин хөдөлгөөнгүй шигшүүрээр дамжин шигшүүрийн доорх бүтээгдэхүүн 2YZ12 тэжээгүүрээр орж конвейерээр дамжин PE15 хацарт бутлуурт орно. Бутлуурт орохын өмнө гар ялгалтаар ФК-92, ФК-85- г ялган авна. Дундаж бутлагдал нь 70 мм хүртэл бутлагдсан бүтээгдэхүүн 4ХХС шигшүүрт орж шигшүүрээс +70мм +40мм -40мм гэсэн 3 бүтээгдэхүүн гарна. Шигшүүрийн дээрх бүтээгдэхүүн буюу +70мм бүтээгдэхүүнийг гар ялгалтаар ялгаж, ФК92, ФК85, ФК75 бүтээгдэхүүн гарна.

Хүснэгт 1. Таваарын хүдэр гаргалтын тооцоо

Олборлох хүдрийн хэмжээ			Гарц, %	Марк	Таваарын хүдэр		
Хүдэр, тн	CaF ₂ -ын агуулга, %	Эрдэс, тн			Хүдэр, тн	CaF ₂ -ын агуулга, %	Минерал, тн
8483	48.44	4108	100	Нийт	8483	47.39	4020
			44.74	ФК-75	3795	75.57	2868
			55.26	ФР	4687	24.55	1151

1.10 Баяжуулах цехийн ажиллах горим, хүчин чадал

Тоон ба чанарын бүдүүвч нь үйлдвэрийн технологийн үндсэн үзүүлэлтүүдийг тогтоодог. Хэрэглэгчид хүргэх жоншны агуулга $\beta=45,75\%$, түүнээс дээш байлгах шаардлага тавьж байна. Анхдагч хүдрийн агуулга, туршилтын үр дүн, хэрэглэгчдийн шаардлага зэргийг үндэслэн үйлдвэрийн бүтээгдэхүүний балансыг дараах байдлаар тооцов.

Хүснэгт 7. Баяжуулах цехийн ажлын горим

№	Үзүүлэлт	Тоо, хэмжээ
1	Жилд ажиллах хоног	220
2	Хоногт ажиллах ээлж	2
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	8

**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хүснэгт 8. Байгаль орчин эдийн засгийн үзүүлэлт

Байгаль орчин	Үзүүлэлт
Физик газар зүйн онцлог:	Тус талбай нь Хэнтийн уулархаг бүсийн зүүн урд төгсгөл Дорнод Монголын хээр талын уул, дов толгод бүхий ойт хээр, хээрийн бүсийн зааг газарт энэхүү талбай оршино. Гадаргуугийн өндөржилт нь 800-1228м. Энэ бүс нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж температур 0.1-0.4°C, хамгийн их дулаан 7-р сард +40.8°C, их хүйтэн 1-р сард -41.6°C байна. Жилд дунджаар 246мм тунадас унах ба ихэнх нь зуны улиралд ногдоно. Салхи ихтэй бөгөөд ихэвчлэн 1.5- 4.5м/с хурдтай салхи зонхилно. Хавар салхины хурд 15м/с хүрэх нь элбэг 9-р сарын сүүлээс хүйтэрч, цас орно. Хүйтний улиралд хөрс 3.0-3.5м хүртэл хөлддөг.
цаг агаар	Дэлхийн Цаг Уурын Байгууллагаас цаг уурын өртөө орчмын 50 км радиуст орших газар нутгуудад, тухайн өртөөний цаг уурын хэмжилтийн утгыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Иймд төслийн объект орчмын уур амьсгалын тодорхойлолтыг цаг уурын “Өндөрхаан” өртөөний олон жилийн ажиглалтын мэдээн дээр тулгуурлан бичлээ. Өндөрхаан өртөө нь анх 1936 онд байгуулагдаж байсан ба хойд өргөргийн 47°19', зүүн уртрагийн 110°38', ДТД 1032.8 м-ийн өндөрт байрлана. Нарны гийгүүлэлт: Нарны гийгүүлэл тухайн орон нутгийн өргөрөг, тэнгэрийн хаяаны хаагдал, үлшил зэргээс ихээхэн хамаарна. Монгол орны хувьд жилийн 230-260 хоног цэлмэг байдаг учраас нарны гийгүүллийн хэмжээ их 2600-3300 цаг байх бөгөөд хоногт дундажаар 8-9 цаг орчим нар гийгүүлнэ. Нарны өндөр хамгийн бага XII сард хоногт 5-7 цаг, нарны өндөр хамгийн их VI сард 9.0-10.5 цаг нар гийгүүлнэ (Жамбаажамц.Б, 1989). “Өндөрхаан” өртөөний хувьд хэвтээ хавтгай дээр тусах нарны шулуун цацрагийн жилийн нийлбэр 2785.7 МДж/м ² , хамгийн бага утга өвөл XII сард 103.0 МДж/м ² , хамгийн их утга дээр дурдсан шалтгаанаар хаврын сүүлч V сард ажиглагдаж 334.5 МДж/м ² хэмжээнд хүрчээ. Зуны саруудад хэвтээ хавтгай дээр тусах нарны шулуун
усан сүлжээ	Гадаргуугийн усан сүлжээ маш муу хөгжсөн, жилийн аль ч улиралд орох хур тундасны хэмжээ Монгол орны дундаж хэмжээнд унадаг. Тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас 30-аад км-т Хэрлэн гол урсдаг. Талбайд ардуудын гаргасан гар худгууд, хааяа уурхайн богино яндант худгууд тааралдана. Судалгааны талбайд эртний нуур цөөрөм байсан ул мөр хонхор хотгор газрууд байх болов ч одоо нэгэнт усгүй болж хагсаж ширгэжээ.
Ургамал	Улирлын хомс тэжээлтэй. Ургамлын чийг Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын дэд их муж, Монголын хээрийн муж, Дундад халхын дэд мужийн Хэнтийн уулын хээрийн тойрогт хамаарагдана. (Юнатов 1984. Өлзийхутаг 1989) Бүлгэмдлийн бүрэлдэхүүн: Крыловын хялгана-таанат бүлэг эвшлийн 1м ² талбайд 2-7 зүйл ургамал бүртгэжээ. Бүлгэмдлийн ноёлогч таана 11-16% -ийн бүрхэцтэй. Stipa krylkvii 6-8% -ийн дэд зонхилохоос гадна Agropyron cristatum 1-2%, Cleistogenes squarrosa 2-3% байнга элбэг, Stipa glareosa, S.gobica, Koeleria macrantha, Leymus chinensis зарим нэг эвшлийн бүрэлдэхүүнд ордог. Улалжаас Carex duriuscula тогтмол элбэгдүү ургана. Алаг өвснөөс Astragalus scaberrimus, Naplophyllum dauricum, Sibbaldia adpressa, Potentilla bifurca зэрэг ургамлууд элбэгдүү тохиолдоно. Сөөгнөөс Caragana bungei, C.pygmaea, C.stenophylla болон заримдаг сөөгөнцрийн Artemisia adamsii, A.caespitosa, Kochia prostrata, Ptilotrichum canescens хаяа нэг

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	<p>тохиолдоно. Цөөн наст ургамлын синузи тод ялгардаггүй. Зарим нэг бүлгэмдэлд Artemisia scoparia, Aster hispidus, Chenopodium album, Dysphania aristida, Salsola collina, S.tragus тааралданахангамжийн нөхцөл: чийг хүрэлцээгүй бүсийн гандуу дэд бүс. Ургамлын чийг хангамж 30-55 хувьтай.</p>
<p align="center">амьтан</p>	<p>Энэ бүс нутагт нь талын ландшафтын өндөрлөг талын (1200-1300 м хүртэл) бага хэрчигдэлтэй, элэгдлийн умард хуурай хэсгийн ландшафттай. Байгалийн мужлалын хувьд давхаргат өндөрлөг тал, үлдмэл цулдмал уул бүхий говь хээрийн дэд мужийн 10 %-аас бага мараа-марз бүхий Умард хуурай хээрийн районд хамаарна. Амьтны аймгийг юуны өмнө сээр нуруугүйтэн ба сээр нуруутан гэсэн хоёр үндсэн бүлэгт ялган авч үзэв. Манай орны төв хэсгийн хээрийн ургамалшилттай нутагт олон салаа гүн их малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллогчид мэрэгчид зонхилно. Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсон үедээ хөрс ургамалд сүрхий сөрөг нөлөө үзүүлдэг. Нөгөө талаар газар малтагч жижиг мэрэгч амьтдын үйл ажиллагааны нөлөөгөөр хээрийн хөрс сийрэгжиж, ургамлан нөмрөг нь баяжиж нийтдээ бэлчээрийн ашиг шим дээшилдэгч явдал бий. Хээрийн бүсийн шувуудын бүрдэлд монгол болжмор нилээд хувийг эзэлнэ.</p> <p>Шавжийн хувьд ядуувтар бүрэлдэхүүнтэй хээрийн шавжийн аймгийн төлөөлөгчид тархсан байна.</p>
<p align="center">эдийн засаг</p>	<p>Талбайн хэмжээнд зам харилцаа сайн хөгжсөн. Ойр зэрэгцээ орших хот суурин газрууд нь Өндөрхаан хот, Бэрх тосгон, Баян-Овоо, Хэрлэн, Батноров сум зэрэг суурин газрууд бөгөөд жилийн дөрвөн улиралд авто хөсөг зорчих сайжруулсан шороон замаар холбогджээ. Өндөрхаан хот зүүн бүсийн тулгуур хот бөгөөд “Мянганы зам” дайран өнгөрнө.</p> <p>Жижиг, дунд үйлдвэр, авто тээвэр, цахилгаан хангамж, аялал жуулчлал, өргөн хэрэглээний барааны бөөний болон жижиглэн худалдааны төвүүдтэй. Нийгэм соёл, сургууль эмнэлгийн үйлчилгээний систем бүрдсэн. Утсан харилцаа аймаг сумдын төвүүдэд 24 цагийн үйлчилгээтэй, байнгын үйлчилгээтэй эмнэлэг сургууль болон үйлчилгээний төвүүдтэй, орон нутгаас ажиллах хүчээр хангах бүрэн боломжтой. 1950-иад онд Бэрхийн жоншны уурхай түшиглэн Бэрх тосгон байгуулагдсан. Жоншны уурхайн ажиллагсад мэргэшсэн уурхайчдын томоохон төвүүдийн нэг болно. Энэхүү тосгон нь Булган уулын ордын жоншны үлдэдэл нөөцийг ашиглах тохиолдолд үйлдвэрлэлд түшиц газар байх бүрэн боломжтой. Ажиллах хүчний нөөц, дэд бүтцийн боломжийн бүрдэл талаас үйлдвэрлэл явуулахад</p>
<p align="center">дэд бүтэц</p>	<p>Түлш шатахуун, хоол хүнс, туслах материалын хангамжийг орон нутгаас бүрэн хангах бололцоотой. Сүүлийн жилүүдэд геологи хайгуулын болон ашигт малтмалын нэлээд хэтийн төлөв бүхий дүүрэгт хамрагдаж байгаагаар судалгааны ажлууд эрчимтэй явагдаж байна. Аймгийн хэмжээнд халх, буриад үндэстэн, ястан амьдардаг. Хүн амын хувьд голдуу газар тариалан, мал аж ахуй эрхлэн амьдардаг. Тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Өндөрхаанаас Бэрх тосгоныг холбосон өндөр хүчдэлийн шугамд холбогдсон.</p>

**БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

1.11 Боломжит нөлөөллийн тодорхойлолт

Хүснэгт 9. Байгаль орчин, нийгэм эдийн засгийн нөлөөллийн тойм

Байгаль орчны элементүүд		Агаарын чанар	Усны чанар	Газрын доорхи усны нөөц	Ургамлын бүтцийн өөрчлөлт	Амьтны аймаг	Хөрсний хими физик шинж чанар	Геологийн тогтоц	Нийгэм-эдийн засгийн нөхцөл	Нийт дүн
№	Төслийн үйл ажиллагаа									
1	Шимт хөрс хуулалт	х	0	0	х	х	х	0	х	5
2	Шимт хөрс хадгалах	0	0	0	х	х	х	0	х	4
3	Хүдэр олборлолт	х	0	0	х	х	х	х	х	6
4	Баяжуулах үйлдвэр	х	х	х	0	х	0	0	0	4
5	Ахуйн хаягдал	х	х	0	х	0	х	0	х	5
6	Шатах тослох материалын агуулах	0	х	0	х	х	х	0	х	5
7	Засварын талбай	0	х	0	х	х	х	0	х	5
	Нийт дүн	4	4	1	6	6	6	1	6	

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тоогоор нь жагсаавал ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний хими-физик шинж чанар, амьтны аймаг, агаарын чанар, усны чанар, газрын доорхи усны нөөц орж байна.

Хүснэгт 10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шалгуур

Төрөл/үнэлгээ	Шалгуур		
М: Хэмжээ, тархалт			
Түвшин=1	Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
Түвшин=2	Дунд зэрэг эсвэл дунд хугацаанд үзүүлэх нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Түвшин=3	Хүчтэй зэрэг эсвэл их хугацаанд үзүүлэх нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Нөлөөллийн түвшин			
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой
Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой
Хүчтэй зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Их хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 жилээс их хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой
S: Хамрах хүрээ буюу газарзүйн тархалт			
Түвшин=1	Нөлөөлөх талбай: төсөл хэрэгжих талбайн хүрээнд		
Түвшин=2	Нөлөөлөх талбай: төслийн талбайн хүрээнээс гадагш 500м зайд		
Түвшин=3	Нөлөөлөх талбай: 500м-ээс цааш талбайг хамарсан		
F: Давтамж буюу магадлал			
Түвшин=1	Магадлал бага: Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсч байсан, гэхдээ энэ төслийн хувьд бараг тохиолдохгүй		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Түвшин=2	Дунд зэргийн магадлалтай- Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой	
Түвшин=3	Өндөр магадлалтай- Энэ төслийн хувьд бараг тохиолдоно.	
Нийт түвшин=MxSxF	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ
Нөлөөллийн түвшин бага	6-аас бага	Тийм ч анхаарал татахуйц биш
Нөлөөллийн түвшин дунд	6-аас 18 хүртэл	Үлэмж - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж, зохицуулах боломжтой
Нөлөөллийн түвшин их	18-аас их	Үлэмж - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж, зохицуулах боломжтой

Нөлөөлөл тус бүрийн хүчил зүйл тус бүрээр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгч тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулав.

Хүснэгт 11. Нөлөөллийн түвшин

Төслийн үйл ажиллагаа	Нөлөөлөлд өртөх объектууд	Шалгуур			Нийт түвшин	
		Хэмжээ, тархалт	Хамрах хүрээ буюу газарзүйн тархалт	Давтамж		
Шимт хөрс хуулалт	Агаарын чанар	1	1	2	2	L
	Ургамлын бүтэц	3	1	3	9	M
	Амьтны аймаг	1	1	2	2	L
	Хөрсний хими физик шинж чанар	2	1	3	6	L
	Нийгэм-эдийн засаг	1	1	1	1	L
Шимт хөрс хадгалалт	Ургамлын бүтэц	1	1	2	2	L
	Амьтны аймаг	1	1	1	1	L
	Хөрсний хими физик шинж чанар	1	1	1	1	L
	Нийгэм-эдийн засаг	1	1	1	1	L
Ахуйн хаягдал	Агаарын чанар	1	1	2	2	L
	Усны чанар	1	1	1	1	L
	Ургамлын бүтэц	2	1	2	4	L
	Хөрсний хими физик шинж чанар	2	1	2	4	L
	Нийгэм-эдийн засаг	2	1	1	2	L
Шатах тослох материалын агуулах	Усны чанар	2	1	2	4	L
	Ургамлын бүтэц	1	1	3	3	L
	Амьтны аймаг	1	1	1	1	L
	Хөрсний хими физик шинж чанар	2	1	3	6	L
	Нийгэм-эдийн засаг	1	2	3	6	L
Засварын талбай	Усны чанар	1	1	1	1	L
	Ургамлын бүтэц	1	1	3	3	L
	Амьтны аймаг	1	1	1	1	L
	Хөрсний хими физик шинж чанар	2	1	3	6	L
	Нийгэм-эдийн засаг	1	1	1	1	L

Жич: L- нөлөөллийн түвшин бага
M-нөлөөллийн түвшин дунд зэрэг

Хүснэгт 12. Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн матриц

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үзүүлэлтүүд	Агаарын чанар	Усны нөөц	Усны чанар	Ургамлын бүтэц	Амьтны аймаг	Геологийн тогтоц	Хөрсний хими физик шинж чанар	Нийгэм эдийн засаг
1	Шимт хөрс хуулалт	2	0	0	9	2	0	6	1
2	Шимт хөрс хадгалалт	0	0	0	2	1	0	1	1
3	Хүдэр олборлолт	9	6	2	4	2	18	4	1
4	Баяжуулах үйлдвэр	6	8	0	0	1	0	1	0
5	Хүдэр тээвэрлэх	9	0	0	6	6	0	6	1
6	Ахуйн хаягдал	2	0	1	4	0	0	4	1
7	Шатах тослох материалын агуулах	4	0	0	3	1	0	6	6
8	Засварын талбай	0	0	1	3	1	0	6	1

Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн матрицаар төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны хам бүрдлийн өртөгдөх байдал, үйлчлэлийг эрэмблэхдээ Байесийн критерийг ашиглав.

$$W_i = \sum_{j=1}^n P_j * R_{ij}$$

Энд:

W_i – Байесийн критер

P_j – Жингийн коэффициент

R_{ij} – Үнэлгээний эрэмбэлэгдсэн үзүүлэлт

Байесийн критерийг ашиглахын тулд эхлээд тухай үзүүлэлтийн жинг тодорхойлох шаардлагатай байдаг. Жингийн коэффициентийг олохдоо Фишборны үнэлгээ болон нийтлэг тохиолдолд жингийн коэффициент ашигладаг аргууд тус бүрээр нь бодож эдгээр утгуудаас Шеноны энтропи ашиглан жингийн коэффициентийн тооцоолсон утгаас сонголт хийв.

Жингийн коэффициент олохдоо дараах дарааллийн дагуу тооцоо хийгддэг байна.

- Экосистемийн төлөв байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйл хоорондын хамаарлыг харуулсан матриц байгуулах
- Орчны төлвийн системийн аль нэг төлөв дэх үнэлгээний эрэмбийн утгыг тодорхойлох
- Эрэмбэлсэн цуваа болон мэдээлэх чадварын үнэлгээний хэмжээсийг тооцоолох
- Жингийн коэффициентуудыг тооцоолох
- Тооцоолсон жингийн коэффициентоос сонголт хийх зэрэг болно.

Хүснэгт 13. Жингийн коэффициентийн утга

№	Фишборны үнэлгээ $P_j = \frac{2 * (n - j + 1)}{n * (n + 1)}$	Томьёо-1 $P_j = \frac{k * (n - j + 1)}{S}$	Томьёо-2 $P_j = \frac{\Delta_j}{\sum \Delta_j}$	Томьёо-3 $P_j = \frac{S_j}{\sum S_j}$
1	0.102	0.066	0.058824	0.04386
2	0.073	0.047	0.007353	0.010965
3	0.117	0.075	0.125	0.107456

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	0.11	0.07	0.080882	0.094298
5	0.11	0.07	0.080882	0.067982
6	0.117	0.075	0.125	0.100877
7	0.102	0.066	0.058824	0.061404
8	0.11	0.07	0.080882	0.083333
9	0.102	0.066	0.058824	0.092105
10	0.102	0.066	0.058824	0.067982
11	0.11	0.07	0.080882	0.08114
12	0.088	0.056	0.036765	0.046053
13	0.095	0.061	0.051471	0.046053
14	0.08	0.051	0.022059	0.026316
15	0.088	0.056	0.036765	0.04386
16	0.088	0.056	0.036765	0.026316

Фишборны үнэлгээ болон нийтлэг тохиолдолд жингийн коэффициент ашигладаг аргуудаар тооцсон жингийн утгийг сонгохдоо Шеноны энтропиг ашигласан. Энэ үр дүнгээр Фишборны үнэлгээр тооцоолсон утга нь мэдээллийн алдагдал багатай болох нь харагдлаа. Иймд Фишборны үнэлгээний утгаар Байесийн критерийг тооцоолов.

Хүснэгт 14. Байесийн критерийн утга

	Агаарын чанар	Усны нөөц	Усны чанар	Ургамлын бүтэц	Амьтны аймаг	Геологийн тогтоц	Хөрсний хими физик шинж чанар	Нийгэм эдийн засаг
Байесийн критерийн утга	8.215	4.632	2.066	10.668	4.521	4.431	10.841	2.457

Дээрх хүснэгтээс үзэхэд хөрсний хими физик шинж чанар хамгийн их нөлөөлөлд өртөх бөгөөд хамгийн бага нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсэг нь нийгэм эдийн засаг юм.

Нөлөөллийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд хөрс, ургамлан бүрхэвч, агаарын чанарт илүүтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Гэхдээ эдгээр нөлөөлөл нь урьдчилан сэргийлж бууруулах боломжтой нөлөөлөл юм. Ийм учраас төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулав.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**1.12 Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт,
ХАМРАХ ХҮРЭЭ**

“Ди Жи Ти энд Эм” ХХК -ийн “Булган Уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс уурхайн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн болон БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан, тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө зэргийг үндэс болгон боловсруулсан.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.13 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар								
1.1	Төсөлд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Уурхайн бүх машин механизмд үзлэг оношилгоо хийлгэх	Уурхайн бүх автомашин	Ширхэг	-			Уурхайн ажил эхлэхээс өмнө	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
1.2		Хүдэр тээвэрлэх машинуудыг тэвшний бүтээлгээр хангаж, ашиглалтад нь хяналт тавих, хурдыг хязгаарлах.	Хүдэр тээврийн бүх автомашин	Ширхэг	-	ҮАЗ	2024		MNS 5885:2008
		Уурхайн ашиглалтын замаас гадна олон салаа зам гаргахгүй байх, дотоод замуудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төсөлд ашиглах замуудад					2024 он	
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
2.1	Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомтол үүсэх	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	2024 оны 3-р улиралд	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2.2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд	-	-	ҮАЗ			
2.3		Тухайн жил уурхайгаас шавхан зайлуулсан усны төлбөрийг гэрээ болон ус ашиглах дүгнэлтэд заасны дагуу төлөх	Төслийн хүрээнд	мян.төг	-	-	ҮАЗ	2024 оны 4 - р улиралд	

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.4		Болзошгүй эрсдэлийн үед булингийг урсгах хамгаалалтын далан суваг шуудууг засаж сайжруулах	Хаягдлын сан түүний ойр орчимд				ҮАЗ	2024 онд тухай бүрд	
3	Хөрсөн бүрхэвч								
3.1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж доройтох	Кемпийн эргэн тойронд хөрс эвдрэхээс сэргийлж ажилчдыг нэг маршрутаар явуулах зорилгоор явган зам хийж гүйцэтгэх	Кемпийн ойр орчимд	м			500.0	2024 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008
3.2		Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу хэлбэржүүлж засах	Шимт хөрсний овоолго	мян.м ³	-			шимт хөрсний овоолго хийх бүрт	
3.3		ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтад хяналт тавих	Үйл ажиллагааны турш					2024 он үйл ажиллагааны турш	
3.4	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг бетон хучилттай талбайд хийх	Засварын талбайд	-	-		Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
3.5		Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Ашиглалтын талбайд	-	-		300.0	2024 он	
		Нийт					800.0		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.14 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Уурхайн тосгонд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх							
	Уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн тосгонд шинээр 100 ш суулгац суулгах	Ширхэг	-	100	1100.0	2024 он Хавар болон намар мод тарих өдрүүдэд	MNS 5917:2023
	Нийт					1100.0		

1.15 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Манай байгууллага нь БОННУ-д тусгасан Хэрлэн сумаас хойд зүгт 5 км-т байрлах 1995 оноос өмнө Барилга угсралтын ажилд шаардагдах шороог өмнө олон жил ашиглаж байснаас үүссэн 2 м дундаж гүнтэй, 1.5 га эвдэгдэж, орхигдсон талбайг нөхөн сэргээх ажлыг 2023-2026 онд хийж гүйцэтгэх ба 2024 онд нийт 0.3 га талбайг нөхөн сэргээх юм.

Хүснэгт 17. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
	БОННУ-д сонгосон талбайд нөхөн сэргээлт хийх	Барилга угсралтын ажилд шаардагдах шороог өмнө олон жил ашиглаж байснаас үүдэн эвдэгдэж, орхигдсон талбайд нөхөн сэргээх юм.	Хэрлэн сумаас хойд зүгт 5 км-т байрлах талбайд	0.3 га талбай	-	1400.0	2024 он 3-р улиралд багтаан хийх	MNS 5917:2008
	Нийт					1400.0		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.16 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно./БОННУ тайлан 2023/

1.17 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уг төслийн БОНБНУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйл гарсан тохиолдолд нэн даруй газар шорооны ажлыг зогсоон төрийн захиргааны төв байгууллагуудад нь мэдэгдэхээр төлөвлөн ажиллах болно.

1.18 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 18. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1. Хөдөлмөр хамгаалал								
1.1	Төслөөс гэнэтийн аваар осол хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он Ажил эхлэхээс өмнө	
1.2		Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид			Үйл ажиллагааны зардал	2024 онд өглөө бүр	
2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх								
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах,	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг	Уурхайн тосгон	3 байршилд	-	300.0	2024 он	MNS5078-2001, MNS 5390:2004,

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Тэсрэх материалын агуулах ШТС					
3. Байгалийн аюул гамшиг								
3.1	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Ажилчид	1 удаа		Үйл ажиллагааны зардал	2024 он 2 болон 3-р улиралд	Гамшгаас хамгаалах тухай хууль,
4. Тэсрэх материалын агуулах								
4.1	Тэсэлгээний ажил болон тэсрэх материалын агуулахтай холбоотой сөрөг нөлөөлөл	Уурхайн тэсэлгээний ажлыг явуулахдаа тэсрэх материалтай харьцах, тэсрэх бодис тээвэрлэх, хадгалах, хураах, устгах ажиллагаанд мөрдөж ажиллах	Тэсрэх материалын агуулах болон тэсэлгээ хийх бүрт	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он үйл ажиллагааны турш	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”,
4.2		Тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх. Гэрээ байгуулах	Тэсэлгээний ажил хийх бүрт	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
		Нийт				300.0		

1.19 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9

Төсөл хэрэгжүүлэгч: “Ди Жи Ти энд Эм” ХХК.

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдлын гэрээг Хэрлэн сумын ЗД-тай байгуулах	Төслийн хэмжээнд	сар	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 оны 3-р улиралд	Хог хаягдлын тухай хууль
3	Ахуйн шингэн хог хаягдал	Шингэн хаягдлыг тусгай бодис ашиглан задлах	Уурхайн бие засах шазар болон шингэн хаягдал цуглуулах цооног				200.0	2024 он Улиралд нэг удаа	
4	Ашиглалтын явцад гарах аюултай хог хаягдал	Төсөлд ашиглагдах автомашинуудаас гарсан хаягдал тос тосолгооны материалыг тунаан баяжуулах үйлдвэрийн тосолгоонд ашиглах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
		Нийт					200.0		

1.20 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Булган Уул” хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулав.

Хэнтий аймгийн Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой хамтран ажиллах.

Хүснэгт 20. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
5. Агаарын чанар								
1.1	Хүхэрлэг хий (SO2)	- ШТС	2023 оны 6-р сард	2		500.0	Хэнтий аймгийн	MNS5061:2001

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Азотын давхар исэл (NO2) Нийт тоосонцор	- Тэсрэх материалын агуулах - Карьер	2023 оны 10 сард				ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS3113:1981 MNS0017.2.5.12:8988
6. Хөрсөн бүрхэвч								
2.1	Ялзмаг, урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO3), хөдөлгөөнт кали (K2O), хөдөлгөөнт фосфор (P2O5), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Хөрсөнд агуулагдах хүнд металл	- Шимт хөрсний овоолго - Тэсрэх материалын агуулах - Засварын газар - Карьер	2023 оны 6-р сард 2023 оны 10 сард	2		300.0	Хэнтий аймгийн ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
7. Усан орчин								
	Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	- Далд уурхайн ус шүүрүүлэх цооног, - Уурхайн унд-ахуйн усны зориулалттай гүний худаг - технологит ашигласан ус	2023 оны 6-р сард 2023 оны 10 сард	2		400.0	Хэнтий аймгийн ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой гэрээ байгуулах	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
8. Эрүүл мэндийн хяналт								
	Ажилчдын эрүүл мэнд	- Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	2023 он	1		-	Эрүүл мэнд төвтэй хамтран ажиллах	
		Нийт				1 200.0		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зураг 2. ОХШХ-ийн дээж, сорьц авах цэгийн байршил



**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.21 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2020 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7	Сар 8.9.10.11		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж захирал хяналт тавин ажиллах	-	x	x	x	Захирал	
2	Сумын байгаль орчны хяналтын байцаагчтай байнгын ажил төрлийн холбоотой байх, заавар зөвлөгөө авах	-	x	x	x	Уурхайн дарга, БО ажилтан	
3	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах				ҮАЗ /гэрээний дагуу/	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
4	БОМТөлөвлөгөө боловсруулах				ҮАЗ /гэрээний дагуу/	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
	Нийт				-		

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “БУЛГАН УУЛ” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.22 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.

Хүснэгт 22. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Хэрлэн сумын 8-р багийн иргэд	ИНХ-д танилцуулах	2024 онд хийгдсэн ажил	4 - р улирал		Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Хэнтий аймгийн БОАЖГазар	БОМТ-ний тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, тайлан хэлбэрээр https://eic.mn/envmng/login.php сайтад оруулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2024 оны 11 дүгээр сард багтаан		Компаний захирал болон уурхайн дарга	Хэнтий аймгийн БОАЖГ- т хүргүүлнэ.
3	БОАЖЯ-ны ХБОБНУГазар	БОМТ-ий биелэлтийн тайланг А-618 тоот журмын дагуу боловсруулан https://eic.mn/envmng/login.php сайтад оруулах	БОМТ-ний хэрэгжилтийн тухай	2024 оны 12 дугаар сард багтаах	ҮАЗ	Компаний захирал болон уурхайн дарга	
	Нийт						

**БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ
ЗАРДАЛ**

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	800.0
2	Нөхөн сэргээлтийн зардал	1100.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	1400.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	300.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	200.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	
8	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1200.0
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	5000.0

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд ус ашигласны төлбөр, хог хаягдлын төлбөрийн хэмжээ болон орон нутагтай хийх нийгмийн хариуцлагын гэрээний төлбөр ороогүй бөгөөд гэрээ хийгдсэний дараа төлбөр нэмж тооцогдоно.